

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

## Агуулга

1	Аудитын гэрчилгээ .....	2
2	Аудитын тайлан.....	3
2.1.	Оршил.....	3
2.2.	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....	3
2.3.	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....	3
2.4.	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин .....	4
2.5.	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ .....	4
2.6.	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал .....	5
2.7.	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар .....	5
2.8.	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн .....	5
2.8.1	Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээлэл .....	5
2.8.2	Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудал.....	8
2.8.2.1	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал.....	9
2.9.	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .....	9
2.10.	Үйл ажиллагааны орлого, зардлын төсөв, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга ...	9
2.11.	Шилэн дансны мэдээлэл .....	10
2.12.	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга .....	10
2.13.	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	11
3	Менежментийн захидал.....	12
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	13

## Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
НББОУС	Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ҮОУС	Үнэлгээний Олон Улсын Стандарт



МИАТ ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ  
ЗАХИРАЛ Д.БАТТӨР ТАНАА

## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:62-26-32-30  
E-mail: info@audit.gov.mn

2019.04.05 № 06/679  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу МИАТ ТӨХК-ийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

### Зөрчилгүй санал дүгнэлт

МИАТ ТӨХК-ийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар МИАТ ТӨХК-ийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

## Үүрэг, хариуцлага

МИАТ ТӨХК нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН  
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

## 1 Аудитын тайлан

### 2.1. Оршил

Монголын Иргэний Агаарын Тээвэр ТӨХК (цаашид “МИАТ ТӨХК” гэх)-ийн 2018 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын дүн, дүгнэлтийг МИАТ ТӨХК-ийн Гүйцэтгэх захирал Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

### 2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу МИАТ ТӨХК-ийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайланд аудит хийлээ.

МИАТ ТӨХК-ийн 2018 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

МИАТ ТӨХК-ийн гүйцэтгэх удирдлага нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг СТОУС болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайланг дээр дурдагдсан хууль болон бодлого, журам, стандартын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2018 оны 9 дүгээр сарын 17-ны өдрөөс 2018 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2018 оны 3 дугаар сарын 15-ны өдөр эцэслэн баталгаажуулж, байгууллагын удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, Хүлэгтхүннү аудит ХХК-ийн Аудитор Ё.Наранбилэгээр ахлуулсан аудитын баг хариуцаж хэрэгжүүлэв.

МИАТ ТӨХК нь 2018 оны санхүүгийн тайлангаа Үндэсний аудитын газарт 2019 оны 2 дугаар сарын 15-ны өдөр 04/0585 дугаар албан бичгээр ирүүлсэн.

### 2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, СТОУС, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

#### **2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

МИАТ ТӨХК-ийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго: “Найдвартай, чанартай, үр өгөөжтэй агаарын тээврийн үйлчилгээгээр Монголыг дэлхийтэй холбосон үндэсний тэргүүлэгч компани байна”

Үйл ажиллагааны чиглэл: Иргэний нисэхийн үйл ажиллагаа

МИАТ ТӨХК-ийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

МИАТ ТӨХК-ийн удирдлага нь дараах голлох хууль, тогтоомжийн хүрээнд компанийн үндсэн үйл ажиллагааг болон санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Иргэний нисэхийн тухай хууль
- Компанийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Татварын багц хууль
- Төсвийн тухай хууль
- Шилэн дансны тухай хууль

Тайлант хугацаанд дээрх хууль, тогтоомжид томоохон шинэчлэлт, өөрчлөлт ороогүй боловч компанийн үндсэн үйл ажиллагааг зохицуулж буй 1999 онд батлагдан гарсан “Иргэний нисэхийн тухай” хуульд өнөөгийн агаарын тээврийн хөгжил, эрсдэл, төрөөс баримталж буй бодлого, цаашдын чиг хандлага зэргийг харгалзан шинэчлэх хэрэгцээ шаардлага үүссэн гэж дүгнэн “Иргэний нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын хуулийн төсөл” боловсруулагдан салбар яамны түвшинд хэлэлцэгдэж байна.

Сангийн сайдын 2018 оны 207 дугаар тушаалаар батлагдсан аргачлалын дагуу газар эзэмших эрхийн болон барилга байгууламжийн ангийн хөрөнгүүдэд санхүүгийн тайлагналын зорилгоор дахин үнэлгээг хийж үр дүнг санхүүгийн тайланд тусгасан байна.

#### **2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

МИАТ ТӨХК-ийн Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

МИАТ ТӨХК-ийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагааг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг хийж гүйцэтгэсэн.

МИАТ ТӨХК нь нягтлан бодох бүртгэл хөтлөлт, санхүүгийн тайланг бэлтгэн гаргахдаа нягтлан бодох бүртгэлийн “Navision” програм хангамжийг ашигладаг.

МИАТ ТӨХК-ийн дотоод хяналтын орчны эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналтын орчныг “үр нөлөөтэй” гэж үзлээ.

## **2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитын явцад МИАТ ТӨХК-ийн бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 42 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 42 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

## **2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар**

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон. МИАТ ТӨХК-ийн санхүүгийн тайлангийн гол мэдээлэл хэрэглэгчид нь Үндэсний аудитын газар, Монгол Улсын Засгийн газар болон зээлдүүлэгчид болно.

Аудитын төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн шатанд нийт орлогыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь компанийн бизнесийн үйл ажиллагаа хэвийн үргэлжилж байгаа, төлөвлөлтийн шатанд орлогын бүртгэлтэй холбоотой эрсдэл нь бусад санхүүгийн элементээс илүү байх магадлалтай гэж тодорхойлсонтой холбоотой юм.

МИАТ ТӨХК-ийн 2018 оны нийт орлого 459,814.8 сая төгрөг /аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлангийн дүнгээр/ бөгөөд түүний 1 хувь болох 4,598.1 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг 2018 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт орлого /олзоос бусад/-ын 1 хувиар тооцсон нь компанийн дотоод хяналтын орчны эрсдэлийг “дунд” гэж үнэлсэнтэй холбоотой юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

## **2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн**

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 6 чиглэлээр төлөвлөсөн 42 горим сорил, гүйцэтгэлийн шатанд нэмж илрүүлсэн эрсдэлд 1 горим сорилыг гүйцэтгэж, үнэлэхэд 28 асуудлыг алдаа, зөрчилгүйд тооцож, 15 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, үүнээс 13 асуудлын алдааг 2018 оны санхүүгийн тайланд залруулсан.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

### **2.8.1 Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээлэл**

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой 21,445.7 сая төгрөгийн дараах 13 алдааг залруулан 2018 оны санхүүгийн тайланд тусгаж, МИАТ ТӨХК-ийн гүйцэтгэх удирдлагаар зөвшөөрүүлэн баталгаажуулав. Үүнд:

- Компани анх үүсгэн байгуулагдсан цагаас хойш хүчингүй билет /нислэг хийгдсэн ч зорчигч өөрөө нисээгүй/-ийн талаарх нягтлан бодох бүртгэлийн бодлого байхгүйгээс

орлогын шалгуур хангасан 13,726.4 сая төгрөгийн өр төлбөр /урьдчилж орсон орлого/-ийг орлогоор хүлээн зөвшөөрч бүртгээгүй байна. Харин тайлант онд дээр дурдсан бодлогыг Гүйцэтгэх захирлын тушаалаар батлан гаргасан байна.

Энэ нь СТУОС-ын Суурь Үзэл Баримтлалын 4.47-д “Эдийн засгийн ирээдүйн үр өгөөжийн өсөлтийг найдвартай хэмжих боломжтой ба энэ нь хөрөнгийг нэмэгдүүлж, эсвэл өр төлбөрийг багасгаж байвал орлогын тайланд орлогоор хүлээн зөвшөөрнө” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланд 13,726.4 сая төгрөгийн УОО-ыг орлогоор хүлээн зөвшөөрч нягтлан бодох бүртгэлийн алдааг залруулсан.

- 2018 оны 1 дүгээр сараас 9 дүгээр сарын хоорондох интерлайн зорчигчийн 683.0 сая төгрөгийн урьдчилж орсон орлогын дүнгээр зорчигчийн орлогыг нэмэгдүүлж, гадаад валютын ханшийг буруу тооцоолж 593.1 сая төгрөгийн орлогыг дутуу бүртгэсэн.

Энэ нь СТУОС-ын Суурь Үзэл Баримтлалын ЧШ12-р зүйлд “... Санхүүгийн мэдээллийг үр ашигтай болгохын тулд уг мэдээлэлд холбоотой юмс үзэгдлийг мөн үнэн зөв илэрхийлнэ. Ийм мэдээлэл иж бүрэн, төв голч, алдаагүй байх нь зүйтэй...”, НББОУС-21 "Гадаад валютын ханшийн өөрчлөлтийн үр нөлөө"-ний 21-р зүйлд “Аж ахуйн нэгж гадаад валютаар гарсан ажил гүйлгээг анх хүлээн зөвшөөрөхдөө тухайн ажил гүйлгээ гарсан өдрийн бүртгэлийн валют ба гадаад валютын хоорондох спот ханшаар гадаад валютын дүнг бүртгэлийн валют руу хөрвүүлэх ёстой” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланд 1,482.0 сая төгрөгийн нягтлан бодох бүртгэлийн алдааг залруулсан.

- Интерлайн зорчигчийн 135.9 сая төгрөгийн орлогыг данс зөрүүлэн өр төлбөрөөр бүртгэсэн, УБ-Пусан чиглэлийн 41.7 сая төгрөгийн орлогыг бүртгээгүй, гадаад валютын ханшийг буруу тооцож 681.5 сая төгрөгийн интерлайн зорчигчийн орлогыг дутуу тус тус бүртгэсэн.

Энэ нь СТУОС-ын Суурь Үзэл Баримтлалын ЧШ12-р зүйлд “... Санхүүгийн мэдээллийг үр ашигтай болгохын тулд уг мэдээлэлд холбоотой юмс үзэгдлийг мөн үнэн зөв илэрхийлнэ. Ийм мэдээлэл иж бүрэн, төв голч, алдаагүй байх нь зүйтэй...”, НББОУС-21 "Гадаад валютын ханшийн өөрчлөлтийн үр нөлөө"-ний 21-р зүйлд “Аж ахуйн нэгж гадаад валютаар гарсан ажил гүйлгээг анх хүлээн зөвшөөрөхдөө тухайн ажил гүйлгээ гарсан өдрийн бүртгэлийн валют ба гадаад валютын хоорондох спот ханшаар гадаад валютын дүнг бүртгэлийн валют руу хөрвүүлэх ёстой” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланд 1,000.1 сая төгрөгийн нягтлан бодох бүртгэлийн алдааг залруулсан.

- Авиа компаниудад үзүүлсэн 644.7 сая төгрөгийн газрын үйлчилгээний орлогыг дутуу бүртгэсэн, Аэрофлот компанитай холбоотой газрын үйлчилгээний 97.8 сая төгрөгийн /нислэг тутамд \$500, нийт 37,000\$/ орлогыг бүртгээгүй байна.

Энэ нь СТУОС-ын Суурь Үзэл Баримтлалын ЧШ12-р зүйлд “... Санхүүгийн мэдээллийг үр ашигтай болгохын тулд уг мэдээлэлд холбоотой юмс үзэгдлийг мөн үнэн зөв илэрхийлнэ. Ийм мэдээлэл иж бүрэн, төв голч, алдаагүй байх нь зүйтэй...” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланд 742.5 сая төгрөгийн нягтлан бодох бүртгэлийн алдааг залруулсан.

- Интерлайн ачаа тээврийн урьдчилж орсон орлогоос 680.0 сая төгрөгийг давхардуулан бууруулж орлогыг 680.0 сая төгрөгөөр илүү бүртгэсэн.

Энэ нь СТУОС-ын Суурь Үзэл Баримтлалын ЧШ12-р зүйлд “... Санхүүгийн мэдээллийг үр ашигтай болгохын тулд уг мэдээлэлд холбоотой юмс үзэгдлийг мөн үнэн зөв илэрхийлнэ. Ийм мэдээлэл иж бүрэн, төв голч, алдаагүй байх нь зүйтэй...” гэж заасантай нийцэхгүй байна.



Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланд 680.0 сая төгрөгийн нягтлан бодох бүртгэлийн алдааг залруулсан.

- Авлагын үнэ цэнэ буурсан 1,319.9 сая төгрөгийн найдваргүй авлагын зардал болон хасагдуулгыг хүлээн зөвшөөрч бүртгээгүй.

Энэ нь НББОУС-39 "Санхүүгийн хэрэглүүр ба хүлээн зөвшөөрөлт"-ийн 63-р зүйлд “Хэрэв хорогдуулсан өртгөөр хэмжсэн санхүүгийн хөрөнгийн үнэ цэний бууралтын гарз үүссэн гэх бодитой нотолгоо байгаа бол уг гарзын дүнг тухайн хөрөнгийн дансны үнийн ба тухайн хөрөнгийн анхны үр ашигт хүүгээр дискаунтчилж тооцоолсон ирээдүйн мөнгөн гүйлгээний өнөөгийн үнэ цэний зөрүүгээр хэмжинэ...” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланд 1,319.9 сая төгрөгийн нягтлан бодох бүртгэлийн алдааг залруулсан.

- "Blue Sky Mongolia" урамшуулалт хөтөлбөрийн хүрээнд бий болсон 294.1 сая төгрөгийн өр төлбөр, зардлыг бүртгээгүй, банканд борлуулсан 168.1 сая төгрөгийн миль борлуулалтын орлогыг бүртгээгүй.

Энэ нь СТОУС-ын Суурь Үзэл Баримтлалын 4.15-д “Өр төлбөрийн гол шинж нь аж ахуйн нэгжийн өнөөдрийн хүлээсэн үүрэг юм. Үүрэг гэдэг нь ямар нэг тодорхой арга замаар хэрэгжих буюу биелэгдэх үүрэг эсвэл хариуцлагыг хэлнэ. Гэрээ байгуулах буюу дүрэм, журмын заалтын дагуу аливаа үүрэг нь хуулийн хүчин төгөлдөр болно”, 4.46-р зүйлд “Одоо байгаа өр төлбөрийг барагдуулснаар эдийн засгийн үр өгөөжийг агуулж байгаа нөөц хасагдах магадлалтай, мөн төлбөрийг барагдуулах дүнг найдвартай хэмжих боломжтой үед өр төлбөрийг балансад хүлээн зөвшөөрнө”, 4.47-д “Эдийн засгийн ирээдүйн үр өгөөжийн өсөлтийг найдвартай хэмжих боломжтой ба энэ нь хөрөнгийг нэмэгдүүлж, эсвэл өр төлбөрийг багасгаж байвал орлогын тайланд орлогоор хүлээн зөвшөөрнө” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланд 1,522.4 сая төгрөгийн нягтлан бодох бүртгэлийн алдааг залруулсан.

- МИАТ компани барьж байгуулахгүй нь тодорхой болсон шинэ нисэх буудлын ангарын барилгын зургийн ажилд төлсөн 298.7 сая төгрөгийн төлбөрийг зардлаар хүлээн зөвшөөрч бүртгээгүй.

Энэ нь СТОУС-ын Суурь Үзэл Баримтлалын 4.52-р зүйлд "Зардал нь эдийн засгийн ирээдүйн үр өгөөжийг бий болгохгүй буюу эдийн засгийн ирээдүйн үр өгөөжийн шалгуур хангагдахгүй байгаа, эсвэл хөрөнгийг балансад хүлээн зөвшөөрөх шалгуур хангагдахаа больсон үед зардлыг нэн даруй орлогын тайланд хүлээн зөвшөөрнө" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланд 298.7 сая төгрөгийн нягтлан бодох бүртгэлийн алдааг залруулсан.

- Өмнөх оны үүссэн авлагаас хүлээн авсан газар эзэмших эрх, агуулахын барилгын 295.3 сая төгрөгийн нягтлан бодох бүртгэлийн алдааны залруулгыг гүйцэтгэхдээ тайлант оны орлогыг бууруулсан.

Энэ нь НББОУС-8 "Нягтлан бодох бүртгэлийн бодлого, Нягтлан бодох бүртгэлийн тооцооллын өөрчлөлт ба алдаа"-ны 44-р зүйлд "Нэг ба түүнээс дээш тайлант үеийн зэрэгцүүлэгдэх мэдээлэлд толилуулсан алдааны тодорхой хугацааны нөлөөг тодорхойлох практик боломжгүй байвал аж ахуйн нэгж өмнөх үе рүү дахин тайлагнах практик боломжтой хамгийн эхний тайлант үеэс /энэ нь тайлант үе байж болно/ хөрөнгө, өр төлбөр ба эздийн өмчийн эхний үлдэгдлийг дахин илэрхийлнэ" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланд 295.3 сая төгрөгийн нягтлан бодох бүртгэлийн алдааг залруулсан.

- Хөрөнгийн дахин үнэлгээний үр дүнг хүлээн зөвшөөрч бүртгэхдээ дахин үнэлгээний дансны үлдэгдлийг харгалзаж үзээгүйгээс 173.9 сая төгрөгийн олз, 64.2 сая төгрөгийн гарзыг бүртгээгүй.

Энэ нь НББОУС-16 "Үндсэн хөрөнгө"-ийн 39-р зүйлд "... Гэхдээ дахин үнэлгээний өсөлтийг тухайн хөрөнгийн дахин үнэлгээний бууралтыг өмнө нь ашиг, алдагдлын хэсэгт хүлээн зөвшөөрсөн бол тэр хөрөнгийн дахин үнэлгээний өсөлтийг мөн адил ашиг, алдагдлын хэсэгт хүлээн зөвшөөрнө ...", 40-р зүйлд "... Гэхдээ дахин үнэлгээний бууралтыг өмнөх дахин үнэлгээний нэмэгдлийн кредит дүнгийн хэмжээгээр бусад дэлгэрэнгүй орлогын хэсэгт хүлээн зөвшөөрч болно ..." гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланд 173.9 сая төгрөгийн нягтлан бодох бүртгэлийн алдааг залруулсан.

- Онгоцны засвар үйлчилгээнд тавьж олгосон 2 ширхэг 103.9 сая төгрөгийн сэлбэгийг бараа материалаас хасаагүй.

Энэ нь СТОУС-ын Суурь Үзэл Баримтлалын 4.49-р зүйлд "Эдийн засгийн ирээдүйн үр өгөөжийн бууралтыг найдвартай хэмжих боломжтой ба энэ нь хөрөнгийг багасах эсвэл өр төлбөрийг нэмэгдүүлэхээр байвал орлогын тайланд зардлыг хүлээн зөвшөөрнө" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланд 103.9 сая төгрөгийн нягтлан бодох бүртгэлийн алдааг залруулсан.

- Ажилтны ээлжийн амралтын олговрыг 0.8 сая төгрөгөөр дутуу тооцоолж олгосон.

Энэ нь “Хөдөлмөрийн тухай” хуулийн 55.1-т “Ажилтанд ээлжийн амралтын хугацаанд ээлжийн амралтын олговор олгоно” гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланд 0.8 сая төгрөгийн зөрчлийг залруулж өглөг үүсгэж бүртгэсэн.

- Дээрх залруулгуудаас үүдэн тайлант үеийн орлогын татварын зардал болон өр төлбөрийг 99.8 сая төгрөгөөр илүү тооцож бүртгэсэн.

Энэ нь СТУОС-ын Суурь Үзэл Баримтлалын ЧШ12-р зүйлд "... Санхүүгийн мэдээллийг үр ашигтай болгохын тулд уг мэдээлэлд холбоотой юмс үзэгдлийг мөн үнэн зөв илэрхийлнэ. Ийм мэдээлэл иж бүрэн, төв голч, алдаагүй байх нь зүйтэй..." гэж зааснаас гажсан байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланд 99.8 сая төгрөгийн нягтлан бодох бүртгэлийн алдаа, зөрчлийг залруулсан.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

## 2.8.2 Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудал

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал:

(сая төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	1	1,389.1	Гүйцэтгэлийн баталгааг хугацаа хоцроон байршуулсан.
2	Албан шаардлага өгсөн	1	2,296.7	Өмнөх оны аудитын 4 зөвлөмжийг дутуу биелүүлсэн.
	Дүн	2	3,685.8	

### 2.8.2.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

- Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 5 зөвлөмжөөс 1 зөвлөмжийг биелүүлж, 4 зөвлөмжийг хэрэгжүүлээгүй. Биелүүлээгүй зөвлөмжийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэхүү тайлангийн 2.12-оос харна уу.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгсөн.

## 2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Дараагийн аудитаар интерлайн зорчигчийн болон ачаа тээврийн "service charge" орлогын бүртгэл, хойшлогдсон татварын хөрөнгө ба өр төлбөрийн бүртгэл, 2019 онд шинээр нэмж түрээслэж байгаа онгоцтой холбоотой ажил гүйлгээ, үйл явдлыг анхаарах шаардлагатай гэж үзэж байна.

Компанийн дүрэм, Хамтын гэрээ, Орон сууцны нөхцөлт дэмжлэг олгох журмыг үндэслэн Гүйцэтгэх захирлын 2018 оны Б/958 дугаар тушаалаар 75 ажилтанд 1,500.0 сая төгрөгийн орон сууцны тэтгэмжийг олгохоор шийдвэрлэж холбогдох зардал, өр төлбөрийг санхүүгийн тайланд бүртгэсэн. Тушаалд хамрагдсан ажилчидтай журмын дагуу нөхцөлт гэрээг хийж, олгосон эсэхийг мөн анхаарч үзэх шаардлагатай.

## 2.10. Үйл ажиллагааны орлого, зардлын төсөв, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Тайлант онд компанийн Төлөөлөн удирдах зөвлөлөөс болон Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас баталсан зорилтот түвшингийн санхүүгийн гол үзүүлэлт, түүний гүйцэтгэл, хэлбэлзлийн талаарх товч дүгнэлтийг дор хураангуйлан харуулав.

2018 оны нислэг тээвэрлэлтийн зорилтот түвшин, түүний гүйцэтгэл:

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2018 он		Өөрчлөлт	
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	тоогоор	хувиар
Зорчигч тээвэрлэлт	мян.хүн	611.9	719.7	107.8	118%
Ачаа тээвэрлэлт	тонн	3,175.7	3,050.8	(124.9)	96%

2018 оны нислэг тээвэрлэлтийн гүйцэтгэлийг өмнөх оны гүйцэтгэлтэй харьцуулсан байдал:

Үзүүлэлт	Хэмжих нэгж	Гүйцэтгэл		Өөрчлөлт	
		2017 он	2018 он	тоогоор	хувиар
Зорчигч тээвэрлэлт	мян.хүн	610.4	719.7	109.3	118%
Ачаа тээвэрлэлт	тонн	2,970.0	3,050.8	80.8	103%

Зорчигч тээвэрлэлтийн тоо өмнөх оноос болон төлөвлөсөн тоо хэмжээнээс ижил 110 орчим мянган хүнээр нэмэгдэж 18 хувийн өсөлтийг үзүүлсэн байна. Харин ачаа тээвэрлэлт батлагдсан төлөвлөгөөнөөс 125 мянган тонноор тасалдаж, 4 хувийн бууралтыг, өмнөх оны гүйцэтгэлтэй харьцуулахад 81 мянган тонноор нэмэгдэж, 3 хувийн өсөлтийг үзүүлсэн байна.

2018 оны орлого, зардал, ашгийн зорилтот түвшин, түүний гүйцэтгэл:

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2018 он		Өөрчлөлт	
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	тоогоор	хувиар
Үйл ажиллагааны орлого	сая.төг	376,554.5	455,303.9	78,749.4	121%
Үйл ажиллагааны зардал	сая.төг	(331,538.1)	(381,760.2)	(50,222.1)	115%
Үйл ажиллагааны бус орлого (зардал)	сая.төг	(33,313.2)	(13,221.0)	20,092.3	40%
ОАТ зардал	сая.төг	(2,475.8)	(8,088.6)	(5,612.8)	327%
Цэвэр ашиг	сая.төг	9,227.4	52,234.1	43,006.7	566%

2018 оны орлого, зардал, ашгийг өмнөх оны гүйцэтгэлтэй харьцуулсан байдал:

Үзүүлэлт	Хэмжих нэгж	Гүйцэтгэл		Өөрчлөлт	
		2017 он	2018 он	тоогоор	хувиар
Үйл ажиллагааны орлого	сая.төг	389,311.2	455,303.9	65,992.6	117%
Үйл ажиллагааны зардал	сая.төг	(324,067.6)	(381,760.2)	(57,692.6)	118%

Үйл ажиллагааны бус орлого (зардал)	сая.төг	(5,346.6)	(13,221.0)	(7,874.4)	247%
ОАТ зардал	сая.төг	(11,739.9)	(8,088.6)	3,651.3	69%
Цэвэр ашиг	сая.төг	48,157.1	52,234.1	4,077.0	108%

2018 оны гүйцэтгэлээр цэвэр ашиг нь төлөвлөсөн хэмжээнээс 43,006.7 сая төгрөгөөр буюу 5.7 дахин өсөхөд компанийн үндсэн үйл ажиллагааны ашиг 28,527.3 сая төгрөгөөр өссөн, үйл ажиллагааны бус зардал 14,479.5 сая төгрөгөөр буурсан, зорчигчийн тоо 110 мянгаар өссөн нь голлох нөлөөг үзүүлсэн байна.

2018 оны төлөвлөгөөнд валютын ханшийн зөрүүнээс хүлээх алдагдлыг хэт өндөр төлөвлөсөн /27,035.9 сая төгрөг/, мөн өмнөх оны гүйцэтгэлээс орлогыг бууруулж, зардлыг өсгөж, цэвэр ашгийн түвшинг бууруулсан нь цэвэр ашгийг 6 дахин өсөхөд нөлөөлсөн байна.

Үйл ажиллагааны бус зардал өмнөх оны гүйцэтгэлээс 7,874.4 сая төгрөгөөр буюу 2.5 дахин өсөхөд төгрөгийн ханш 215.79 төгрөгөөр суларсан<sup>1</sup> нь гол нөлөөг үзүүлсэн байна. Өмнөх онд гадаад валютын ханшийн зөрүүнээс 6,009.4 сая төгрөгийн цэвэр олз, тайлант онд 13,401.7 сая төгрөгийн цэвэр гарз хүлээсэн байна.

## 2.11. Шилэн дансны мэдээлэл

МИАТ ТӨХК нь “Шилэн дансны тухай” хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

МИАТ ТӨХК нь Шилэн дансны тухай хуулийн дагуу shilendans.gov.mn системд байршсан нийт 7 бүлэг мэдээллийг хугацаанд нь оруулсан байна.

Тус байгууллагын Шилэн дансны тухай хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

## 2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 5 зөвлөмж өгснөөс 2018 онд 1 зөвлөмжийг биелүүлж, 4 зөвлөмжийг биелүүлээгүй, зөвлөмжийн биелэлт 20 хувьтай байна. Биелүүлээгүй зөвлөмжид а) Хугацаа хэтэрсэн 138 харилцагчийн 1,583.7 сая төгрөгийн авлагын асуудал, б) Байнгын ажлын байранд хөлсөөр ажиллах гэрээгээр ажиллаж байгаа ажилчдын асуудал, в) “Lufthansa technik” компаниас авах 713.0 сая төгрөг /\$291,037/-ийн авлагын асуудал, г) агаарын хөлгийн дахин үнэлгээг хийгээгүй асуудал багтаж байна.

Зөвлөмж биелэгдээгүй нь компанийн Төлөөлөн удирдах зөвлөл холбогдох шийдвэрийг гаргалгүй хойшлуулсан, СТОУС-ын дагуу дахин үнэлгээг гүйцэтгээгүй, гэрээний эрх зүйн маргаантай холбоотой асуудалд компанийн хуульчдыг түлхүү оролцуулаагүйгээс шалтгаалсан байна. Өгсөн зөвлөмжийг биелүүлэхгүй байгаа, хугацаа алдаж байгаа нь компанийн хүлээх алдагдал, эрсдэлийг нэмэгдүүлэх үр дагавартай. Иймд Төрийн аудитын тухай хууль, тогтоомжийн дагуу албан шаардлагыг өгсөн.

Мөн Үндэсний аудитын газрын аудитын баг МИАТ ТӨХК-ийн гадаад орон дахь 6 төлөөлөгчийн газруудын санхүүгийн үйл ажиллагаанд 2018 оны 10 дугаар сарын 22-ноос 11 дүгээр сарын 16-ны хооронд 2017 оны дотоод хяналтаар илэрсэн зөрчилд өгсөн зөвлөмжийн биелэлт, 2018 оны 3 улирлын байдлаарх орлогын бүрдүүлэлт, зарцуулалт, авлага, өглөгийн тулган баталгаажуулах шалгах, холбогдох хууль, дүрэм журам болон байгууллагын дотоод журмыг мөрдөн ажиллаж байгаа эсэхэд завсрын аудит хийсэн байна.

МИАТ ТӨХК-ийн гадаад орон дахь төлөөлөгчийн газруудад хийсэн завсрын аудитаар бүртгэл тайлагнал, батлагдсан төсвийн зарцуулалт, авлага, өглөг, орлого бүрдүүлэлт, үндсэн хөрөнгөтэй холбоотой 545.4 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснийг төлөөлөгчийн газруудын удирдлагад танилцуулан асуудлын бүртгэлээр баталгаажуулан ажилласан байна.

<sup>1</sup> 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн албан ханш: 1usd=2,427.13 mnt, 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн албан ханш 1usd=2,642.92mnt. Эх сурвалж: mongolbank.mn

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

### **2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид МИАТ ТӨХК-ийн 2018 оны санхүүгийн тайланд аудит хийхдээ АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

МИАТ ТӨХК-ийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тусгасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, стандартад нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

## **2 Менежментийн захидал**

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидал АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтэд үндэслэсэн болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь МИАТ ТӨХК-ийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

### **3.1 Онгоцны шатахууны худалдан авалттай холбоотой асуудал**

#### **3.1.1 Илрүүлэлт:**

2018 оны 9 дүгээр сарын 3-нд онгоцны шатахуун худалдан авах, тээвэрлэх, сумлахтай холбоотой гурван багц тендерийг зарлаж Содмонгол ХХК, Мэргэван ХХК шалгаран гэрээ байгуулах мэдэгдлийг 2018 оны 10 дугаар сарын 29-ны өдөр хүлээн авсан байна. Содмонгол ХХК, Мэргэван ХХК нь тендерийн баримт бичигт заасан хугацаанаас хоцроон гүйцэтгэлийн баталгааг ирүүлсэн нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн зарим заалттай нийцээгүй байна.

Энэ нь “Эрх ба үүрэг” батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3, 42 дугаар зүйлийн 42.1.2 дахь заалттай нийцээгүй байна.

#### **3.1.2 Эрсдэл:**

Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулаагүйгээс маргаан үүсэх эрсдэлтэй.

#### **3.1.3 Өгсөн зөвлөмж:**

Онгоцны шатахуун худалдан авах, тээвэрлэх, сумлахтай холбоотой худалдан авалтын ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулж байх зөвлөмжийг өгсөн.

#### **3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:**

Аудитын зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 9 дүгээр сарын 10-ны өдрийн дотор албан тоотоор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

				/төгрөгөөр/	
Мөрийн дугаар	Балансын зүйл	2017 оны 12-р сарын 31-ний өдөр	2018 оны 12 сарын 31-ний өдөр		
1	<b>Хөрөнгө</b>				
1.1	<b>Эргэлтийн хөрөнгө</b>				
1.1.1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	42,072,916,386.21	16,758,428,179.16		
1.1.2	Дансны авлага	22,442,974,076.30	30,477,124,981.67		
1.1.3	Татвар НДШ-ийн авлага	1,099,849,725.75	1,471,667,754.89		
1.1.4	Бусад авлага	4,223,230,073.81	2,002,703,197.88		
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө	-	42,170,597,111.29		
1.1.6	Бараа материал	29,965,161,077.47	32,945,578,369.01		
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	13,787,315,109.29	13,720,997,845.04		
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө	-	-		
1.1.9	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө /борлуулах хөрөнгийн бүлэг/	-	-		
1.1.10		-	-		
1.1.11	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>113,591,446,448.83</b>	<b>139,547,097,438.94</b>		
1.2	<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>				
1.2.1	Үндсэн хөрөнгө	141,670,694,727.47	140,991,861,506.54		
1.2.2	Биет бус хөрөнгө	2,408,851,202.78	12,167,041,119.98		
1.2.3	Биологийн хөрөнгө	-	-		
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт	-	-		
1.2.5	Хайгуул үнэлгээний хөрөнгө	-	-		
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө	-	-		
1.2.7	Хөрөнгө оруулалтын зорилготой үлд хөдлөх хөрөнгө	-	-		
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө	28,585,346,361.23	31,940,613,771.23		
1.2.9		-	-		
1.2.10	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>172,664,892,291.48</b>	<b>185,099,516,397.75</b>		
1.3	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>286,256,338,740.31</u></b>	<b><u>324,646,613,836.69</u></b>		
2	<b>Өр төлбөр ба эзэмшигчийн өмч</b>				
2.1	<b>Өр төлбөр</b>				
2.1.1	<b>Богино хугацаат өр төлбөр</b>				
2.1.1.1	Дансны өглөг	27,392,971,799.39	30,663,158,652.73		
2.1.1.2	Цалингийн өглөг	750,819,384.30	630,877,511.09		
2.1.1.3	Татварын өр	17,539,493,407.33	10,827,624,602.35		
2.1.1.4	НДШ-ийн өглөг	-	-		
2.1.1.5	Богино хугацаат зээл	85,573,660,209.58	46,805,021,365.04		
2.1.1.6	Хүүний өглөг	2,133,466,895.84	2,466,300,957.31		
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг	-	-		
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	44,947,865,115.11	32,547,638,152.68		
2.1.1.9	Нөөц /өр төлбөр/	-	-		
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	1,664,920,490.70	972,632,756.53		
2.1.1.11	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө /борлуулах хөрөнгийн бүлэг/-нд хамаарах өр төлбөр	-	-		

Мөрийн дугаар	Балансын зүйл	2017 оны 12-р сарын 31-ний өдөр	2018 оны 12 сарын 31-ний өдөр
2.1.1.12		-	-
<b>2.1.1.13</b>	<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>180,003,197,302.25</b>	<b>124,913,253,997.73</b>
2.1.2	<b>Урт хугацаат өр төлбөр</b>		
2.1.2.1	Урт хугацаат зээл	125,524,307,454.37	143,195,107,094.52
2.1.2.2	Нөөц /өр төлбөр/	-	-
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр	-	-
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр	3,327,262,337.43	3,603,988,029.17
2.1.2.5		-	-
<b>2.1.2.6</b>	<b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>128,851,569,791.80</b>	<b>146,799,095,123.69</b>
<b>2.2</b>	<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>308,854,767,094.05</b>	<b>271,712,349,121.42</b>
2.3	<b>Эзэмшигчдийн өмч</b>		
2.3.1	Өмч: -Төрийн өмч	5,577,283,000.00	5,577,283,000.00
2.3.2	-Хувийн өмч	-	-
2.3.3	-Хувьцаат	-	-
2.3.4	Халаасны хувьцаа	-	-
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал	-	-
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	2,513,855,032.53	15,651,158,561.09
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	-	-
2.3.8	Эзэмшигчийн өмчийн бусад хэсэг	2,338,262,860.76	2,338,262,860.76
2.3.9	Хуримтлагдсан ашиг алдагдал	(33,027,829,247.03)	29,367,560,293.42
2.3.10		-	-
2.3.11	<b>Эзэмшигчдийн өмчийн дүн</b>	<b>(22,598,428,353.74)</b>	<b>52,934,264,715.27</b>
2.4	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>286,256,338,740.31</b>	<b>324,646,613,836.69</b>



**4.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан**

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	<b>Борлуулалтын орлого ( цэвэр )</b>	<b>389,311,223,805.02</b>	<b>455,303,869,247.91</b>
2	Борлуулсан барааны өртөг	294,388,904,212.70	344,601,951,598.76
3	<b>Нийт ашиг ( алдагдал )</b>	<b>94,922,319,592.32</b>	<b>110,701,917,649.15</b>
4	Түрээсийн орлого	165,666,667.17	228,033,443.95
5	Хүүний орлого	3,393,528,546.02	4,269,300,785.61
6	Ногдол ашгийн орлого	-	-
7	Эрхийн шимтгэлийн орлого	-	-
8	Бусад орлого	929,363,284.55	13,606,297.61
9	Борлуулалт, маркетингийн зардал	1,384,004,367.42	1,701,956,007.12
10	Ерөнхий ба удирдлагын зардал	18,515,811,305.55	22,248,397,935.40
11	Санхүүгийн зардал	12,292,531,143.09	11,887,975,989.39
12	Бусад зардал	13,330,698,550.81	5,241,679,686.51
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	6,009,364,617.15	(13,401,737,698.66)
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	(298,693,636.36)
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүсэх олз (гарз)	-	-
17	Бусад ашиг ( алдагдал)	(147,199.08)	(109,709,148.32)
18	<b>Татварын өмнөх ашиг (алдагдал)</b>	<b>59,897,050,141.26</b>	<b>60,322,708,074.56</b>
19	Орлогын татварын зардал	11,739,940,527.88	8,088,630,598.43
20	<b>Татварын дараах ашиг (алдагдал)</b>	<b>48,157,109,613.38</b>	<b>52,234,077,476.13</b>
21	<b>Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг алдагдал</b>	-	-
22	<b>Тайлант үеийн цэвэр ашиг алдагдал</b>	<b>48,157,109,613.38</b>	<b>52,234,077,476.13</b>
23	<b>Бусад дэлгэрэнгүй орлого</b>	-	-
23-1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	-	-
23-2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-
23-3	Бусад олз (гарз)	-	-
24	<b>Орлогын нийт дүн</b>	<b>48,157,109,613.38</b>	<b>52,234,077,476.13</b>
25	<b>Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)</b>		

### 4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>1</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	<b>390,727,648,367.44</b>	<b>460,749,805,201.72</b>
	Бараа борлуулсан, үйчилгээ үзүүлсний орлого	389,849,692,498.95	452,514,460,167.69
	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	-	-
	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	298,850,443.50	519,518,296.57
	Буцаан авсан татвар	-	-
	Татаас, санхүүжилтийн орлого	-	-
	Бусад мөнгөн орлого	579,105,424.99	7,715,826,737.46
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	<b>342,235,528,704.07</b>	<b>405,679,472,824.28</b>
	Ажиллагчдад олгосон мөнгө	36,228,818,218.16	40,881,932,810.52
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн мөнгө	6,222,170,980.00	7,010,341,782.92
	Бараа материал худалдан авахад төлсөн	2,475,997,161.85	2,860,418,424.96
	Ашиглалтын зардал төлсөн	577,837,348.28	545,533,511.62
	Түлш шатахуун тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн мөнгө	92,129,240,775.10	116,316,302,983.51
	Хүүний төлбөрт төлсөн	11,939,583,860.91	11,294,451,306.15
	Татварын байгууллагад төлсөн	6,442,113,586.30	19,353,976,563.13
	Даатгалын төлбөрт төлсөн	4,992,371,629.53	5,178,205,336.55
	Бусад мөнгөн зарлага	181,227,395,143.94	202,238,310,104.92
<b>1.3</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>48,492,119,663.37</b>	<b>55,070,332,377.44</b>
<b>2</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	<b>2,455,598,647.91</b>	<b>4,768,589,529.58</b>
	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	-	-
	Биет бус хөрөнгө борлуулсны орлого	-	-
	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого	-	-
	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого	-	-
	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	-	-
	Хүлээн авсан хүүний орлого	2,455,598,647.91	4,768,589,529.58
	Хүлээн авсан ногдол ашиг	-	-
		-	-
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	<b>1,940,442,369.00</b>	<b>44,376,656,271.15</b>
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	1,885,549,809.50	2,153,259,159.86
	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	14,310,000.00	52,800,000.00
	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	-	42,170,597,111.29
	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-

	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	40,582,559.50	-
			-
<b>2.3</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>515,156,278.91</b>	<b>(39,608,066,741.57)</b>
<b>3</b>	<b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	<b>52,747,800,000.00</b>
	Зээл авсан, өрийн үнэт цаас авснаар хүлээн авсан		52,747,800,000.00
	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	-
	Төрөл бүрийн хандив	-	-
			-
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	<b>35,636,000,563.47</b>	<b>94,488,507,667.81</b>
	Зээл, өрийн үнэт цаасны төлбөр төлсөн мөнгө	34,016,074,199.63	89,672,796,707.81
	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	36,166,363.84	-
	Хувьцаа буцаан худалдан авахад төлсөн	-	-
	Төлсөн ногдол ашиг	1,583,760,000.00	4,815,710,960.00
			-
3.3	<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(35,636,000,563.47)</b>	<b>(41,740,707,667.81)</b>
4	Валютын ханшны зөрүү	<b>610,314,925.41</b>	<b>963,953,824.89</b>
5	<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>13,981,590,304.22</b>	<b>(25,314,488,207.05)</b>
6	<b>Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>28,091,326,081.99</b>	<b>42,072,916,386.21</b>
7	<b>Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>42,072,916,386.21</b>	<b>16,758,428,179.16</b>

4.4 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Өмч	Халаасны хувьцаа	Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	Эзний өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	<b>2017 оны 01 сарын 01-ний өдрийн үлдэгдэл</b>	<b>5,577,283,000.00</b>	-	-	<b>2,513,855,032.53</b>	-	<b>2,338,262,860.76</b>	<b>(33,027,829,247.03)</b>	<b>(22,598,428,353.74)</b>
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга								-
3	Залруулсан үлдэгдэл	<b>5,577,283,000.00</b>	-	-	<b>2,513,855,032.53</b>	-	<b>2,338,262,860.76</b>	<b>(33,027,829,247.03)</b>	<b>(22,598,428,353.74)</b>
4	Тайлант үеийн ашиг (алдагдал)							-	-
5	Бусад дэлгэрэнгүй орлого								-
6	Өмчид гарсан өөрчлөлт								-
7	Зарласан ногдол ашиг								-
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн								-
9	<b>2018 оны 01-р сарын 01-ний өдрийн үлдэгдэл</b>	<b>5,577,283,000.00</b>	-	-	<b>2,513,855,032.53</b>	-	<b>2,338,262,860.76</b>	<b>(33,027,829,247.03)</b>	<b>(22,598,428,353.74)</b>
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга							14,977,023,024.32	14,977,023,024.32
11	Залруулсан үлдэгдэл	<b>5,577,283,000.00</b>	-	-	<b>2,513,855,032.53</b>	-	<b>2,338,262,860.76</b>	<b>(18,050,806,222.71)</b>	<b>(7,621,405,329.42)</b>
12	Тайлант үеийн ашиг (алдагдал)							52,234,077,476.13	52,234,077,476.13
13	Бусад дэлгэрэнгүй орлого					-	-		-
14	Өмчид гарсан өөрчлөлт	-							-
15	Зарласан ногдол ашиг							4,815,710,960.00	4,815,710,960.00
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн				13,137,303,528.56				13,137,303,528.56
17	<b>2018 оны 12 сарын 31-ний өдрийн үлдэгдэл</b>	<b>5,577,283,000.00</b>	-	-	<b>15,651,158,561.09</b>	-	<b>2,338,262,860.76</b>	<b>29,367,560,293.42</b>	<b>52,934,264,715.27</b>

#### 4.5 Аудит хийсэн зорилтот түвшний гүйцэтгэлийн тайлан

№	Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	2017 оны гүйцэтгэл	2018 он				Харьцуулалт (%иар) 2018 2017
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Биелэлт		
						Тоогоор	Хувиар	
1	Зорчигч тээвэрлэлт	мян.хүн	610.4	611.9	719.7	107.8	117.6	117.9
2	Ачаа тээвэрлэлт	тонн	2,970.0	3,175.7	3,050.8	(124.9)	96.1	102.7
3	Зорчигч эргэлт (нийт)	сая.хүн.км	1,182.5	1,232.0	1,385.3	153.3	112.4	117.1
4	Ачаа эргэлт (нийт)	сая.тн.км	7.7	8.6	7.7	(0.9)	89.6	100.3
5	Шилжүүлсэн тонн-километр (нийт)	сая.тн.км	114.1	119.5	132.4	12.9	110.8	116.0
6	<b>Нийт орлого</b>	сая төг	<b>393,799.8</b>	<b>377,754.5</b>	<b>459,879.0</b>	82,124.5	121.7	116.8
6.1	Агаарын тээврийн үндсэн үйл ажиллагааны орлого	сая төг	364,182.0	350,842.9	422,440.1	71,597.2	120.4	116.0
6.2	Үндсэн бус үйл ажиллагааны орлого	сая төг	25,129.2	25,711.6	32,863.7	7,152.1	127.8	130.8
6.3	Үйл ажиллагааны бус орлого	сая төг	4,488.6	1,200.0	4,575.1	3,375.1	381.3	101.9
7	<b>Нийт зардал</b>	сая төг	<b>333,902.7</b>	<b>366,051.3</b>	<b>399,556.3</b>	33,504.9	109.2	119.7
7.1	Агаарын тээврийн үндсэн үйл ажиллагааны зардал	сая төг	324,067.6	331,538.1	381,760.2	50,222.1	115.1	117.8
7.1.1	Үндсэн үйл ажиллагааны зардал	сая төг	292,247.3	302,864.6	344,602.0	41,737.4	113.8	117.9
7.1.2	Нэмэлт зардал	сая төг	31,820.3	28,673.5	37,158.2	8,484.7	129.6	116.8
7.1.2.1	Ерөнхий нэмэгдэл зардал	сая төг	10,422.7			-		-
7.1.2.2	Үндсэн хөрөнгийн элэгдэл	сая төг	1,390.3			-		-
7.1.2.3	Зээлийн хүү	сая төг	10,573.3			-		-
7.2	Үндсэн бус үйл ажиллагааны зардал	сая төг	-			-		
7.3	Валютын ханшийн зөрүүгийн бодит олз, гарзын хэлбэлзлийн дүн	сая төг	7,227.2	27,035.9	33,289.6	6,253.7	123.1	460.6
7.4	Валютын ханшийн зөрүүгийн бодит бус олз, гарзын хэлбэлзлийн дүн	сая төг	(13,236.6)	-	(19,887.8)	(19,887.8)		150.2
7.5	Үйл ажиллагааны бус зардал	сая төг	15,844.5	7,477.3	4,394.3	(3,083.0)	58.8	27.7
8	Татварын өмнөх ашиг (алдагдал)	сая төг	<b>59,897.1</b>	<b>11,703.2</b>	<b>60,322.7</b>	48,619.6	515.4	100.7
8.1	Үндсэн ажиллагааны ашиг (алдагдал)	сая төг	<b>46,660.5</b>	<b>11,703.2</b>	<b>40,434.9</b>	28,731.7	345.5	86.7
8.2	Агаарын тээврийн үндсэн үйл ажиллагааны ашиг (алд)	сая төг	<b>40,114.4</b>	<b>19,304.8</b>	<b>40,679.9</b>	21,375.1	210.7	101.4
9	Орлогын албан татвар	сая төг	11,739.9	2,475.8	8,088.6	5,612.8	326.7	68.9
10	Цэвэр ашиг/(алдагдал)	сая төг	48,157.1	9,227.4	52,234.1	43,006.7	566.1	108.5
11	Орлогын 1 төгрөгт ногдох зардал	төг	<b>0.848</b>	<b>0.969</b>	<b>0.869</b>	(0.1)	89.7	102.5
12	Авлага	сая төг	27,282.4	26,750.0	33,951.5	7,201.5	126.9	124.4
13	Өглөг	сая төг	308,854.8	286,658.8	271,712.3	(14,946.5)	94.8	88.0
14	Хөрөнгө оруулалт	сая төг	3,550.7	9,193.2	5,900.9	(3,292.3)	64.2	166.2

Аудитын явцад илэрсэн алдаа

Огноо:

2018.03.22

Аудитын нэр:

Монголын Иргэний Агаарын Тээвэр ТӨХК-ийн 2018 оны санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код:

САГ-2019/55/СТА-ТӨҮГ

Шалгагдсан байгууллагын

Монголын Иргэний Агаарын Тээвэр ТӨХК

Сая төгрөгөөр

№	Аудитын зорилт, чиглэл	Тоо	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
					Нэр	Албан тушаал	Овог нэр
А	1	2	3	4	5	6	7
1	Өмнөх аудит болон зөвлөмжийн биелэлт, үр дүн	1	2017 оны санхүүгийн тайлангийн аудитаар 5 зөвлөмж өгсөн ба үйлчлүүлэгч 1 зөвлөмжийг хэрэгжүүлж, 4 зөвлөмжийг хэрэгжүүлэхээр тодорхой арга хэмжээг авч хэрэгжүүлсэн боловч тайлагналын өдрөөр бүрэн хэрэгжиж дуусаагүй байна.	2,296.7	Албан шаардлага	Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга болон Гүйцэтгэх захирал	Р.Мэргэн /ТУЗ-ын дарга/, Д.Баттөр /Гүйцэтгэх захирал/
2	Зардлын данстай холбоотой асуудал	1	2018/9/3-нд шатахуун худалдан авах тухай 3-н багц тендерийг зарлаж Содмонгол ХХК 2 багцад, Мэргэван ХХК 1 багцад шалгаран гэрээ байгуулах мэдэгдлийг 2018/10/29-ны өдөр хүлээн авсан байна. Содмонгол ХХК, Мэргэван ХХК нь тендерийн баримт бичигт заасан хугацаанаас хоцроон гүйцэтгэлийн баталгааг ирүүлсэн нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн зарим заалттай нийцээгүй байна.	1,389.10	Зөвлөмж	Гүйцэтгэх захирал болон Тэргүүн дэд захирал	Д.Баттөр /Гүйцэтгэх захирал/, Н.Ганболд /Тэргүүн дэд захирал/

Бэлтгэсэн: Аудитор

Ё.Наранбилэг

Огноо

Анхан шатанд хянасан: ЧХМенежер

Е.Оюундэлгэр

Огноо



